



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2023 оны 06 сарын 14 өдөр

Дугаар 310

Улаанбаатар хот

**“Монгол кино нэгтгэл” төрийн өмчит үйлдвэрийн
газрын захирлыг томилох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 19 дүгээр зүйл, Хөдөлмөрийн тухай хуулийн 65 дугаар зүйл, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Авлигатай тэмцэх газрын 2023 оны “Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг хянасан тухай” 05/10771 дугаар албан бичгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Соёлын сайдаас ирүүлсэн 2023 оны 1/1347 дугаар албан бичгээр ирүүлсэн саналыг үндэслэн “Монгол кино нэгтгэл” төрийн өмчит үйлдвэрийн захирлаар Будсүрэнгийн Түмэн-Өлзийг 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн томилсугай.

2. “Монгол кино нэгтгэл” төрийн өмчит үйлдвэрийн захирал Б.Түмэн-Өлзийгийн ажлыг хүлээлцүүлэхийг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

3. “Монгол кино нэгтгэл” төрийн өмчит үйлдвэрийн захирлаар Б.Түмэн-Өлзийтэй Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

4. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

5. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 63 дугаар тогтоолын 2 дахь заалтын хүчингүй болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ